



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/581

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн “Аймгийн 2021 оны төсөвт тодотгол хийх тухай” 05/07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 2021 оны 05/07 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 2,1 дэх заалтад тусгагдсан “Ковид-19 цар тахалтай холбоотой эрүүл мэндийн салбарт тоног төхөөрөмжийн зардал”-ын 1 дүгээр багц “Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд хүчил төрөгчийн системийн багцын зардал 16,500,000 (арван зургаан сая таван зуун мянга) төгрөгийг зарцуулах эрхийг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал (Э.Хүдэрчулуун)-д үүрэг болгосугай.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, үр дүн, хэрэгжилтийг тайлагнахыг Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн захирал (Э.Хүдэрчулуун)-д үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101234